

СЭТГҮҮЛ ЗҮЙН ЕРӨНХИЙ ОНОЛЫГ БОЛОВСРУУЛАХ
ОНОЛ-АРГА ЗҮЙН АСУУДАЛД

М. Зулькафиль*

* МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн профессор, шинжлэх ухааны доктор (Sc.D)

Түлхүүр үг: сэтгүүл зүйн метаонол, олон нийтийн харилцаа, онтологийн түвшин, шинжлэх ухааны ойлголтуудын аппарат, мэдээллийн ерөнхий онол

Сэтгүүл зүйн шинжлэх ухааны хамгийн тулгамдсан асуудлуудын нэг бол сэтгүүл зүйн ерөнхий онолыг боловсруулах явдал юм. Зарим судлаач тийм метаонол байгаагүйгээс сэтгүүл зүйг бүхэлд нь авч үзэх, дотоод харилцаа холбоо болон бусад мэдлэгийн салбар, хэсгүүдтэй яаж холбогдох талаар бүрэн ойлголт авахад түвэгтэй гэж дүгнэдэг нь үндэслэлтэй юм. Сэтгүүл зүйн ерөнхий онолыг боловсруулахын гол бэрхшээл нь сэтгүүл зүйн шинжлэх ухааны өмнө тулгарч буй хэд хэдэн онолын асуудалтай холбоотой юм.

Нэг дэх тулгамдсан асуудал бол бусад нийгэм-хүмүүнлэгийн шинжлэх ухаануудын дотор сэтгүүл зүйн онол өөрөө өөрийгөө тодорхойлохтой холбоотой гэж үзэж болно. Хэрэв бид сэтгүүл зүйг бусад нийгмийн шинжлэх ухааны судлагдахуунтай холбон тайлбарлах юм бол энэ асуудал нэлээд хүндрэлтэй болох нь ойлгомжтой. Тэгж

хандах нь профессор В. А. Сидоровын бодлоор "өөрийнхөө ач холбогдол, практик үйл ажиллагааны хувьд эдийн засаг, улс төр, социологиос хамаагүй өргөн, хамаагүй үр нөлөөтэй сэтгүүл зүйг бидэнд нийтлэг нийгмийн амьдралын объектив шинж гэж үзэх боломжгүй болгох"¹ юм.

Бусад нийгмийн болон хүмүүнлэгийн шинжлэх ухааны дотор сэтгүүл зүй онолоо өөрөө тодорхойлох боломж нь түүнд зөвхөн ганцхан тохиолдолд л боломжтой. Энэ нь сэтгүүл зүй өөрийнхөө мөн чанарыг илрүүлэх (онтологийн түвшин), судалгааны объект, судлагдахууныг тодорхойлох (гносеологийн түвшин), салбар ухаануудын дундаас нийгмийн бодит байдлыг судлах, таньж мэдэх өөрийн гэсэн арга ба арга зүйг олж боловсруулах (арга зүйн түвшин), сэтгүүл зүйн үйл ажиллагааны үнэт зүйлсийн ба ёс зүйн талуудыг илрүүлэх (аксиологийн ба деонтологийн түвшин), сэтгүүл зүй дэх хүний эзлэх байр суурийг тодорхойлох (антропологийн түвшин), мөн сэтгүүл зүйн метаонолын үндсэн зорилго ба зорилтуудыг томъёолох чадвартай байх явдал юм. Дээр дурдсан түвшнүүдийг оновчтой хослох замаар сэтгүүл зүйн онол ба

практикийн янз бүрийн хэсгүүдийн хоорондох ерөнхий уялдаа холбоог эрж хайх, илрүүлэх боломжтой.

Хоёр дахь гол асуудал бол сэтгүүл зүйн онолын категорийн системийг боловсруулах, өөрөөр хэлбэл нийгмийн үзэгдэл болох сэтгүүл зүйн мөн чанарыг нэгдмэл түвшинд, бүхэлд нь ойлгоход тусалдаг ерөнхий, хамгийн гол ойлголтуудыг боловсруулахтай холбоотой юм. Ингэхийн тулд юуны өмнө сэтгүүл зүйн метаонолын төв категорийг олж илрүүлэх, дараа нь түүний эргэн тойронд бүх категорийн аппаратыг бүрдүүлэх шаардлагатай.

Тиймээс сүүлийн үед судлаачид сэтгүүл зүйн ерөнхий онолыг боловсруулах үндэслэлийг төдийгүй судалгааны янз бүрийн хандлагуудыг боловсруулж буй онолын хүрээг тодорхойлж, сэтгүүл зүйн бусад онолуудтай харилцан уялдаа холбоог илүүлж эхэлсэн байдаг. Тухайлбал, ОХУ-ын судлаачид сэтгүүл зүйд түүний онтологи, гносеологи, аксиологи, деонтологи, антропологи, соёл судлал болон бүтцийн тэнцвэрт байдлын үүднээс хандах иж бүрэн философиин үзэл баримтлалыг боловсруулж эхэлсэн нь анхаарал татдаг.

Одоо сэтгүүл зүйн ерөнхий онолын философиин үндэслэл болон дээр дурдсан түвшнүүдийн талаар товч ярья. Онтологи (грекийн *ontos* – мөн чанар, *logos* – сургаал) бол ахуй болон түүний төрөл, шинжүүдийн талаарх философиин сургаал юм. Тэгвэл сэтгүүл зүйн хувьд онтологи нь сэтгүүл зүйн мөн чанар, түүний нийгмийн ертөнцөд орших хэлбэрүүд, сэтгүүл зүй дэх ертөнцийн дүр зургийн тусгал, нийгэмд оршин эргэлдэж буй янз бүрийн мэдээллийн урсгалын үүсэл, түгээлтийн хуулиудын талаарх сургаал гэж ойлгож болно.

Бидний бодлоор энэхүү онтологийн асуудлуудыг боловсруулах явцад сэтгүүл зүйн нийгмийн үзэгдэл болох хамгийн гол, хамгийн ерөнхий шинж чанаруудыг эрж хайх боломжтой юм. Сэтгүүл зүйн онтологийн зорилт бол нийгмийн ертөнц дэх сэтгүүл зүйн ахуйн нэгдмэл дүрийг бүтээх, үүгээр дамжуулан ертөнцийг таньж мэдэх чиг баримжааны системийн үүргийг гүйцэтгэх онцлогтой.

Сэтгүүл зүйг гносеологийн хувьд авч үзвэл танин мэдэхүйн онолын үүднээс сэтгүүл зүйг бодит байдлыг таньж мэдэх тусгай хэлбэрт хамааруулж болно. Танин мэдэхүйн энэ төрлийн гол онцлог бол рациональ болон уран сайхны аргуудын хослол байдаг.

Философиин толь бичгүүдэд "аксиологи" (грекийн *axios* – үнэт зүйл, *logos* – үг, ойлголт) хэмээх нэр томъёог үнэт зүйлсийн тухай сургаал, хүний үйл ажиллагааны чиглэл, хандлага, үйл хөдлөлийн шалтгааныг тодорхойлдог ерөнхий зарчмуудын тухай философиин онол гэж тодорхойлсон байдаг. Субъектийн талаас үнэт зүйлд хандах хандлага бол үндсэн хоёр аргаар хэрэгждэг: нэг талаар, үнэлэт өгч буй объектийг үнэт зүйлд хамааруулах, нөгөө талаар түүнийг тунгаан ойлгох явдал юм. Судлаачдын тэмдэглэснээр үнэт зүйлс гэдэг бол аливаа зорилго эсвэл үзэгдэлд тодорхой утга өгч буй тэр зүйл мөн. Үнэт зүйл дангаараа ахуй болж чадахгүй, зөвхөн утга агуулдаг. Тэд санаа зориг, зорилго руу хандсан шаардлагуудын утгыг илэрхийлдэг. Тиймээс үнэт зүйлсийг зөвхөн ёс суртахууны үнэт зүйлстэй, аксиологийг зөвхөн ёс зүйн үнэт зүйлстэй хамаатай зүйл гэж ойлгож болохгүй. Нэг талаар сэтгүүлч нийгэмд хэрэгтэй, нөгөө талаар түүний бүтээл, олон талт бүтээлч үйл ажиллагаа нь бас л

нийгэмд хэрэгтэй. Энэ утгаараа сэтгүүл зүй хүний оюуны амьдралын чухал суваг болох замаар нийгмийн ач холбогдол бүхий үнэт зүйлсийн үүргийг гүйцэтгэдэг онцлогтой юм.

Сэтгүүл зүйн чухал шинжийн нэг бол деонтологийн шинж мөн. Деонтологи гэдэг бол үүрэг болон ёс суртахууны шаардлагуудын (заавар зөвлөмжийн хэлбэрээр илэрхийлэгдсэн ёс суртахууны бүхий л шаардлага) асуудлуудыг судалдаг ёс зүйн салбар юм. Сэтгүүл зүйн нэрт онолч Е. П. Прохоров сэтгүүл зүйн деонтологийг арай өргөн хүрээнд авч үзэхийг санал болгоод "мэргэжлийн харилцааны бүхий л хүрээн дэх үүргийн нийлбэр бөгөөд түүний систем нь нийгмийн эрх ашгийн төлөө үйлчилж буй сэтгүүл зүйн үйл ажиллагааны хуулиар зохицуулагддаг"² гэж тэмдэглэсэн байдаг. Тэгвэл профессор О. Л. Гнатюк сэтгүүл зүйн деонтологийн түвшний хязгаарыг арга зүйн хувьд эрх зүйн ба ёс зүйн гэж ангилахыг санал болгосон байдаг. Түүний бодлоор сэтгүүл зүйн деонтологийн эрх зүйн (гадаад) түвшин нь ОНМХ ба төр засаг, ОНМХ ба нийгэм, иргэд, ОНМХ ба иргэний, эдийн засгийн, төрийн институтууд зэрэг системийн нэгэн адил ОНМХ-ийн үйл ажиллагааг зохицуулах хуулиудыг сэтгүүл зүйн практикт хэрэгжүүлэх үйл явцтай холбоотой юм. Тэрээр сэтгүүлчийн албан үүргийн хэм хэмжээ нь ОНМХ-ийн хүрээн дэх хууль эрх зүйн баримт бичгүүдэд тусгалаа олсон бөгөөд сэтгүүлч тэр хуулиудын заалт, хэм хэмжээг сахин ажиллах ёстой гэснийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй юм.

Сэтгүүл зүйн деонтологийн ёс зүйн (дотоод) түвшин нь сэтгүүлч үйл ажиллагаагаа амжилттай явуулахад шаардлагатай эрх, үүрэг, мэргэжлийн шаардлагуудын талаар нэгдмэл

ойлголт өгдөг онцлогтой. Энэ бол субъектив шинжтэй түвшин бөгөөд тэнд үйл ажиллагааны аль ч салбарын "гадаад" бодит хуулиуд хүний дотоод үүрэг, мэргэжлийн албан үүргийн хүрээ руу шилжих болно. Сэтгүүлчийн үүрэг гэдэг бол юуны өмнө мэргэжлийн харилцааны бүхий л хүрээн дэх үүргүүдийн нийлбэр бөгөөд түүний систем нь сэтгүүл зүй хэмээх нийгмийн өвөрмөц институтын үйл ажиллагааны хуулиудаар зохицуулагдана³.

Сэтгүүл зүй бол антропологийн шинжийг агуулдаг бөгөөд түүний судлагдахуун нь субъектуудын нийгмийн социаль болон оюуны орчин дахь боломж, тэдний харилцан нөлөөлөл, харилцан үйлчлэлийн зарчим, хэмжээ хязгаар, өвөрмөц онцлог мөн.

Одоо сэтгүүл зүйн янз бүрийн асуудлууд нийгэм-хүмүүнлэгийн онолуудад болон энэ онолуудыг судалдаг хичээлүүдэд яаж илэрдэг талаар товч өгүүлье.

Юуны өмнө сэтгүүл зүйн нийгэм-хүмүүнлэгийн онолууд төлөвших үял явц янз бүрийн салбар ухааны зааг дээр явагдсаныг хэлэх хэрэгтэй. Тиймээс сэтгүүл зүйн боловсролын хөгжлийн явцад төлөвшиж бий болсон мэдлэгийн нийлбэр нь цомтгох буюу интеграл шинжтэй гэдэг нь тодорхой. Бусад шинжлэх ухааны салбаруудын судлагдахуунтай идэвхтэй харилцан уялдаа холбоонд оршдог нь сэтгүүл зүйн мэдлэгийн янз бүрийн салбар үүсч төлөвшихэд хүчтэй нөлөө үзүүлсэн бөгөөд өнөөдөр тэдний ихэнх нь сургалтын хөтөлбөрт орж, ирээдүйн сэтгүүлчид янз бүрийн хичээлийн түвшинд судалж байна. Тиймээс сэтгүүл зүйн нийгэм-хүмүүнлэгийн үндсэн онолуудын гол онцлог шинжүүдийн талаар товч өгүүлье.

Сэтгүүл зүйн социологи бол сэтгүүл зүйн нийгмийн мөн чанарыг илрүүлэх зорилготой бөгөөд энэ хичээлийг судалснаар оюутан нийгэм-хүмүүнлэгийн хичээлүүдээс олж авсан мэдлэгийг нийгмийн үзэгдэл болох сэтгүүл зүйн үйл ажиллагаа, сэтгүүл зүйн онолын мэдлэгтэй хослох замаар нийгэм, нийгмийн үйл явц, бие хүний тухай нэгдмэл суурь мэдлэг, төсөөлөлтэй болно. Энэхүү онолын хичээлийг заах шаардлага бол сэтгүүл зүйн практикт тодорхой чиг баримжаа олж авах хэрэгцээнээс урган гарсан байдаг. Бодит туршлага бол эргэцүүлэн бодох тулах цэг, онолын дүн шинжилгээ хийх материал, сэтгүүл зүйн социологийн салбарт олж авсан шинэ мэдлэгийг баяжуулах тэр бодит байдал мөн. Энэ хичээлийн зорилго нь нийгмийн бодит байдал дахь сэтгүүл зүйн болон сэтгүүлчийн үүрэг, байр, тэдний нийгмийн бүлгүүд, институтууд, нийгмийн байгууллагууд, хувь хүмүүстэй харилцах үйл явц дахь ач холбогдлыг тодорхойлох, сэтгүүл зүйн бүтээгдэхүүнийг нийгмийн амьдралыг таньж мэдэх чухал эх сурвалж гэж хүлээж авах, сэтгүүлчийн нийгмийн соёлын талаарх төсөөллийг төлөвшүүлэх, ОНМХ-ийн үйл ажиллагаа болон мөн чанарыг ойлгохын тулд нийгмийн бодит байдлыг судлах социологийн аргуудын тусламжтайгаар хэвлэл мэдээллийн практикт тохирсон сэтгүүлчийн арга зүйн хэрэгслүүдийг баяжуулахад оршино.

Энэ хичээлийг судалснаар оюутан сэтгүүл зүйн практик үзэгдлүүдэд дүн шинжилгээ хийх, өөрийнхөө мэргэжлийн дагуу мэдлэгийн эх сурвалжуудтай ажиллах дадал, чадвартай болж, сэтгүүлчийн хөдөлмөрийн нийгмийн зүй тогтлууд, нийгэм дэх мэдээллийн харилцааны бусад субъектуудтэй

харилцан уялдаа холбооны талаар тодорхой төсөөлөлтэй болно.

Сэтгүүл зүйн сэтгэл зүй нь түүний сэтгэл зүйн мөн чанарыг илрүүлэхэд чиглэгдсэн байдаг. Энэ хичээлийг судлах явцад шинжлэх ухааны ерөнхий систем дэх сэтгэл зүйн мэдлэгийн ач холбогдол, эзлэх байрыг ойлгох, шинэ судлагдахууны шинжлэх ухааны ойлголтуудын аппаратыг эзэмших зэрэг асуудлуудыг шийдвэрлэх болно. Дурдсан хичээлийг судалсны үр дүнд оюутан өдөр тутмын нийтлэл, нэвтрүүлэг бүтээх болон редакцийн ажилд сэтгэл зүйн дүн шинжилгээ хийх, сэтгэл зүйн мэдлэгийг практикт хэрэгжүүлэх арга, дадал, чадварыг эзэмших, хүртэхүйн үйл явцыг зохицуулах сэтгэл зүйн хуулиудын тухай хүн амын янз бүрийн давхаргад үр ашигтай нөлөөлөх орчин үеийн аргуудын тухай төсөөлөл олж авах, соёлыг нийтлэл, радио-телевизийн нэвтрүүлгийг үнэлэх, шүүмжлэх, сэтгэл зүйн мэдлэгийн арга, хэрэгслүүдийг ашиглах, мөн нийгмийн үзэл санаагаар тоглохын эсрэг тэмцэх, орчин үеийн сэтгэл зүйн арга барилын талаар мэргэжлийн чиг баримжаатай болох, ОНМХ-ийн редакцийн, теле, киноны студийн хамт олны дунд сэтгэл зүйн хувьд эрүүл саруул, ажил хэрэгч, тогтвортой уур амьсгалыг бүрдүүлэхэд нөлөөлөхүйц нийгмийн сэтгэл судлаачдын үр ашигтай арга, технологийг ашиглах дадал, чадварыг эзэмшинэ.

Сэтгүүл зүйн сурган хүмүүжүүлэх талын зорилго нь сэтгүүл зүйн хичээлийг заах үзэл баримтлалыг боловсруулахад оршино. Мөн энэ хичээлийн зорилгын хүрээнд шинжлэх ухааны үндэстэй сурган хүмүүжүүлэх ажиллагаанд системтэй хандах, багшлах ажлыг зохион байгуулах, норматив бааз болон

сэтгүүл зүйн хичээлүүдийг заах арга, хэлбэрийг судлах асуудал багтана. Энэ хичээлийг судалснаар оюутан шинжлэх ухаанд болон сурган хүмүүжүүлэх практикт тогтсон сэтгүүл зүйн хичээлүүдийг заах үзэл баримтлал, багшлах үйл ажиллагааны нөхцөл, сэтгүүл зүйн дэг сургуулийн уламжлалын талаар мэдэх, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө болон бусад сургалт-арга зүйн баримт бичгүүдийн талаар тодорхой чиг баримжаа олж авах, сургалтын янз бүрийн төрөл, хэлбэрт шаардлагатай сургалт-арга зүйн баримт бичгүүдийг боловсруулах чадвартай болох, сэтгүүл зүй хичээлүүдийг заах сургалт-арга зүйн зорилтуудыг шийдвэрлэх янз бүрийн хувилбарууд болон сэтгүүл зүйн шилдэг сургуулиудын туршлагын талаар тодорхой мэдлэг, төсөөлөл олж авна.

Сэтгүүл зүйн түүхийн зорилго нь сэтгүүл зүй хэмээх нийгмийн үзэгдлийн үүсэл, төлөвшил, хөгжлийн үе шатуудын талаар оюутнуудад иж бүрэн төсөөлөл олгоход оршино.

Нийтлэл зүйн онол нь бодит байдлыг тусгах, эзэмших нийтлэлийн арга, хэлбэрүүдийг боловсруулах зорилготой. Нийтлэл зүй нийгэм-улс төрийн үйл ажиллагааны өвөрмөц салбар болохын хувьд өөрийнхөө урт удаан жилийн түүхийн туршид олон нийтийн санаа бодолд улс нөлөөлөх, түүнчлэн нийгмийн бодит байдлыг өөрчлөн шинэчлэх зорилго агуулж ирсэн. Нийтлэл зүйд анхаарах болсон

шалтгаан нь нийгмийн хөгжлийн практик өөрөө шаардах болсонтой, сэтгүүл зүй дэх нийтлэл зүйн үүрэг, ач холбогдлыг ойлгох явдалтай, нийгэм-улс төрийн үйл ажиллагааны энэ төрийн орчин үеийн бодит байдлыг болон нийтлэл зүйн нөлөөлөх боломжийг судлах шаардлагатай холбоотой юм. Энэ судлагдахуун нь нийтлэл зүйн болон улс төрийн нөлөөллийн онцлогийг ойлгох онолын

хандлагуудын хувьсал хөгжил, мөн улс төрийн үйл явц дахь нийтлэл зүйн үүргийг тодорхойлсон байдаг. Үүнийг судалсны үр дүнд оюутан нийгмийн ач холбогдолтой баримтуудыг тайлбарлах, дүн шинжилгээ хийх нийтлэг аргуудыг эзэмших, нийтлэл-уран сайхны бичлэгийн

төрөл, зүйлээр материал бичих дадал, чадвартай болох, олон нийтэд нөлөөлөх аргуудыг эзэмших болно.

Сэтгүүлчийн бүтээлч үйл ажиллагааны үндэс бол сэтгүүлчийг мэргэжлийн түвшинд бэлтгэх ажлын хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэг мөн. Сэтгүүлчийн бүтээлч ажиллагааны асуудал бол сэтгүүл зүйн боловсролын хамгийн тулгамдсан, гол анхаарлаа хандуулах ёстой асуудлуудын нэг юм. Сэтгүүлчийн уран бүтээл бол хувь хүний оюуны, сэтгэл зүйн, зориг тэвчээрийн зэрэг бүхий л хүрээг, ухамсар, дотоод ухамсар зэрэг сэтгэл зүйн бүх түвшнийг хамарсан хүнд хэцүү үйл явц байдаг. Тиймээс энэ төрлийн бүтээлч үйл ажиллагаа хүнээс тусгай бэлтгэл шаардах нь зүйн хэрэг юм. Энэ


хичээлийг судалснаар оюутан бүтээлч үйл ажиллагааны үндсэн үе шат, бүтээлч чадварыг хөгжүүлэх арга зам, сэтгэх, тунгаан бодох, урьдчилж харах ажлын онцлогийг мэдэж, нийтлэл, нэвтрүүлэх бүтээх арга, дадал, чадвар болон бусад олон зүйлийг эзэмших учиртай юм.

Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйлийн онол бол сэтгүүлчийн бүтээлийн гол зүй тогтлууд, арга ба төрөл зүйлийн уялдаа холбоо, агуулга ба хэлбэрийн харьцаа, тухайн бүтээл дэх утга санаа ба дүрийн, зохиогчийн санаа бодол ба төрөл зүйлийн илэрхийлэл, бүтээлийн зорилго ба хүлээн авагчийн хүсэн хүлээж буй зүйлийн уялдаа холбоо, харьцаа зэрэг зүйлүүдийг илрүүлэх онцлогтой юм. Энэ асуудалд олон талаас нь иж бүрэн хандахгүйгээр бичлэгийн төрөл, зүйлийн системийн мөн чанар, онцлог шинжийг төдийгүй тэдний ангиллын

асуудлыг ч бүрэн гүйцэд ойлгох боломжгүй юм.

Оюутнууд энэ хичээлийг судлах явцад бичлэгийн төрлүүдийн харилцан нөлөөлөл ба нэгдэн нийлэх боломж, бичлэгийн төрөл зүйлийн системийн өөрчлөн шинэчлэгдэх үйл явц, зүй тогтлууд, бичлэгийн төрөл зүйлүүдийн хувьсан хөгжих шалтгаан, уламжлал шинэчлэлийн асуудлууд, эцэст нь сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйлүүдийн хэв маяг, бүтцийг мэдэх шаардлагатай. Учир нь бичлэгийн төрөл зүйлд стистемтэй хандахгүйгээр тэдний дотоод бүтцийн өөрчлөлт болон шинээр үүсэн бий болж буй боломжуудын учрыг олох нь амаргүй юм.

Энэ бүхнээс үзэхэд сэтгүүл зүйн ерөнхий онол нь онол-арга зүйн түвшинд философи, нийгэм-хүмүүнлэгийн болон хавсралт шинжлэх ухааны салбар, хичээлүүдтэй салшгүй холбоотой гэдэг нь тодорхой байна.



Хүснэгт 1. Сэтгүүл зүйн ерөнхий онолын онол-арга зүйн үндэслэл, түүний мэдлэгийн бусад салбартай холбогдох нь

Одоо сэтгүүл зүй ба олон нийтийн харилцааны онолын харилцан хамаарал, харилцан нөлөөллийн тухай товч өгүүлэв. Шинжлэх ухааны аль ч салбарын үүсэл, хөгжил нь бодит байдал ба мэдлэгийн үзэгдлийн аль нэг салбарын туршлага, практикийг нэгтгэх хэрэгцээ, шаардлагатай холбоотой байдаг. Сэтгүүл зүй болон олон нийтийн харилцааны онолын үүсэл, төлөвшил ч тийм маягаар явагдсан. Тэдний танин мэдэхүйн объект нь хүн төрөлхтний соёл иргэншлийн эхний үед үүссэн аман болон бичгийн үгийн тусламжтайгаар зөвхөн хүмүүсийн хоорондох мэдээлэлээс гадна олон нийтийн мэдээлэл дамжуулж эхэлсэн үеийн мэдээллийн үйл явцыг судлах явдал байлаа. Мэдээллийг олшруулах, түгээх тогтмол хэвлэл, радио, телевиз, компьютерийн технологи, Интернет зэрэг техник хэрэгсэл бий болсноор "сэтгүүл зүй", "олон нийтийн харилцаа", "массмедиа", "ОНМХ", "олон нийтийн харилцааны хэрэгсэл" зэрэг ойлголт үүсч, тэдний тусламжтайгаар олон нийтийн мэдээллийг үйлдвэрлэх, олшруулах, түгээх үйл ажиллагаатай холбоотой маш олон үзэгдлийг тайлбарлах, илэрхийлэх боломж бүрдсэн. Өнгөрсөн зууны дунд үед энэхүү олон нийтийн мэдээллийн үйл явцыг өөрийнхөө судалгааны объект, судлагдахуун болгодог шинжлэх ухаан үүсч, төлөвшиж эхэлсэн. Үүнийг социализмын дараах орнуудад сэтгүүл зүйн онол, Өрнөдийн орнуудад харилцааны онол гэж нэрлэдэг. Өөр өөр онол-арга зүйн хандлагын үндсэн дээр хөгжиж ирсэн шинжлэх ухааны энэ хоёр салбар өнөөдөр шинжлэх ухааны бие даасан хоёр өөр салбарын түвшинд байгаа бөгөөд зарим асуудлын хувьд эрс өөр өөр үзэл баримтлалтай, зарим асуудлын хувьд

харилцан уялдаа холбоотой, өөр нэг асуудлын хувьд нэг нь нөгөөгөө нөхсөн шинжтэй байна. Одоо энэхүү харилцаа холбоо, харилцан нөлөөллийн тухай авч үзье.

Өрнөдийн орнуудад харилцааны шинжлэх ухаан үүсч харьцангуй богино хугацаанд бие дааж хөгжиж чадсан нь орчин үеийн харилцааны хэрэгслүүд, мэдээлэл болон харилцааны шинэ технологи, массмедиа, реклам сурталчилгааны хүрээнд өрнөсөн объектив хүчин зүйл, зүй тогтлуудтай шууд холбоотой юм. Судлаачийн тэмдэглэснээр "Харилцааны түүх бол бүх хэрэгслүүдийн хөгжил, өөрөөр хэлбэл мэдээлэл дамжуулах сувгуудын, тэмдэгт-бэлгэдийн хэлбэрт кодлогдсон мэдээллийг зөөгчдийн хөгжил юм. Энэ бол хүнийг харилцааны амьтан болон төлөвшүүлэх харилцааны түүхэн хэлбэрүүдийн хөгжил мөн" юм. АНУ-ын Колорадогийн их сургуулийн проффессор Р. Т. Крейгийн бодлоор харилцааны онолын орчин үеийн байдалд философи, социологи, хэл шинжлэл, кибернетик, антропологи, соёл судлал, сэтгэл судлал, логиоос эхтэй долон үндсэн уламжлал нөлөөлсөн байна. Энэ бол:

- 1) Илтгэх урлагийн уламжлал. Харилцааг яриа явуулах практик урлаг гэж үздэг бөгөөд үүнд урлаг, арга, хүлээн авагч, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн төсөөлөл, логик, үндэслэл зэрэг нэр томьёог түгээмэл ашигладаг.
- 2) Тэмдэгтийн уламжлал. Энд харилцааг тэмдэгтүүдийн тусламжтайгаар субъектүүдийн хоорондох харилцан нөлөөлөл гэж үздэг. Түгээмэл ашигладаг нэр томьёо нь тэмдэгт, бэлгэдэл, ач холбогдол, код, хэл, илэрхийлэл, утга санаа юм.
- 3) Үзэгдлийн уламжлал. Энд харилцааг харилцан яриа, бусад туршлагын

оршин тогтнох боломж гэж үздэг. Туршлага, "би", "бусад", харилцан яриа, нээлттэй байдал, дэмжлэг, жинхэнэ эх зэрэг нэр томьёог ашигладаг байна.

4) Кибернетикийн уламжлал. Энэ бол харилцааг мэдээллийг боловсруулах үйл явц гэж үздэг бөгөөд үүнийг эх сурвалж, хүлээн авагч, дохио, мэдээлэл, дуу чимээ, эргэх холбоо, сүлжээ зэрэг нэр томьёоны тусламжтайгаар тайлбарладаг.

5) Нийгмийн сэтгэл зүйн уламжлал. Харилцааг харилцан нөлөөлөл, нөлөө, илтгэсэн санаа бодол гэсэн утгаар авч үздэг. Үүнийг зан байдал, үр нөлөө, үзэл суртал, эсэргүүцэл, бие хүн, сэтгэлийн хөдлөл, мэдрэмж, хүртэхүй, танин мэдэхүй, харилцан нөлөөлөл зэрэг нэр томьёоны тусламжтайгаар тайлбарладаг байна.

6) Нийгэм соёлын уламжлал. Харилцааг нийгмийн дэг журмын үйлдвэрлэл, нөхөн үйлдвэрлэл гэж ойлгодог бөгөөд үүнийг нийгэм, бүтэц, практик, дүрэм журам, нийгэмжилт, соёл, ижилсэл, хамтын үйл ажиллагаа зэрэг нэр томьёоны тусламжтайгаар илэрхийлдэг байна.

7) Шүүмжлэлт уламжлалд олон нийтийн харилцааг эргэцүүлэл, үзэл суртлын ноёрхол, байнга өөрчлөгдөж буй ярианы нөхцөл байдал гэж ойлгож ирсэн байна⁵.

Дээрх уламжлал сэтгүүл зүйн онолын төлөвшилд зохих хэмжээгээр нөлөөлсөн гэж хэлж болно. Гэхдээ тодорхой тайлбар хийх зайлшгүй шаардлага бий. Сэтгүүл зүй нийгмийн үзэгдлийн хувьд төлөвшиж эхэлсний үр хөврөлийг соёлын эхний үе шатанд буюу олон нийтэд хандсан үгийг чадвартай эзэмших явдал зөвхөн нийгмийн харилцааны төдийгүй удирдлагын олон талт, чухал хэрэгсэл болж байсан үед төлөвшиж эхэлснийг

нийтлэл зүйгээс ажиглаж болно. Үнэхээр эртний Грек, Ромд уран үгийн сургуулиуд үүсч, тэнд хүмүүс яруу илтгэх, үгийн урлагт буюу санаа бодлоо үгээр оновчтой дамжуулах дадал чадварт суралцаж эхэлсэн түүхтэй. Цэцэн мэргэн үгийг сонирхогч-тэнүүлчдийг, мөн яруу илтгэх урлагийн багш нарыг софистууд гэж нэрлэж байсан бөгөөд тэд сургалтаа төлбөртэй явуулдаг байжээ. Гэхдээ бүр тэр үед софистуудыг үгийн утга санаанаас илүү гоёж чимсэн уран үгийн араас хөөцөлдөж, асуудалд хэт өнгөцхөн хандсанаас үнэнийг олох, гол зүйлийг барьж авахад түвэгтэй гэж шүүмжилдэг байв. Тиймээс яруу илтгэгч-софистуудын эсрэг янз бүрийн нийгмийн зүтгэлтнүүд, нэрт уран илтгэгчид, тэдний дотор Антифон, Андокид, Исократ, Демосфен, Динарх зэрэг хүмүүс зогсож байсан ажээ. Тэдний уран үг тухайн үед улс төрийн зэвсэг болж байсан онцлогтой. Нийтлэл зүй илтгэх урлаг үргэлжилсэн үгийн бүтээлийн өвөрмөц төрөл төдийгүй нийгэм-улс төрийн үйл ажиллагааны төрлийн хувьд үүсэх үндэс болсон нь санамсаргүй зүйл биш юм.

Түүхийн баримт мэдээлэлд өнгөцхөн хандах аргаар хэдийгээр олон нийтийн харилцаа болон сэтгүүл зүйн үүсэх түүхийн эх сурвалж нь нийтлэг шинжтэй боловч төлөвших явцын бүр эхний үе шатанд бие даасан хоёр чиглэл болон салсныг амархан ажиглаж болно. Хэрэв олон нийтийн харилцааны илтгэх урлагийн уламжлал нь яриа өрнүүлэх практик урлаг байсан бол нийтлэл зүйн уламжлал нь олон нийтийн үзэл бодолд нөлөөлөх зорилгоор нийгмийн маргаан мэтгэлцээнд шууд оролцох явдал гэж үзэх үндэстэй юм. "Уран илтгэгч-яруу илтгэгч" хоёрыг эсрэг тавих нь эртний Грек, Ромын

нийгмийн гол шинж байв. Ингэхдээ нэг дэхийг үгийн урлагийн улс төрийн тэмцлийн зэвсэг болгон ашигладаг т-р нийгмийн зүтгэлтэн гэсэн утгаар, хоёр дахийг үгийн урлагийн онол, ярианы уран чадварын дэг жаягийг сайн мэддэг, гэхдээ улс төрийн маргаан, мэтгэлцээнд оролцохыг зорилго болгодоггүй хүмүүс гэж ойлгож иржээ. Харилцааны анхны мэргэжлийн төлөөлөгчдийн хоорондох зарчмын ялгаа чухам үүнд ошиж байсан бөгөөд тэдний хоорондох эсрэг тэсрэг байр суурь эртний Грек, Ромын нийгмийн оюуны бүхий л амьдралын туршид үргэлжилсэн түүхтэй юм.

Судлаач В. В. Учёновагийн тэмдэглэснээр “эртний Грек, Ромын нийгэмд уран үгийн улс төрийн утга агуулга, түүний цаг үеэ олсон байдал, дэвшүүлж буй санал дүгнэлтийн практикийн бодит байдалд хандсан чиг баримжаа, нээлттэй байдал нь улс төрийн аман яриа болон нийтлэл зүйн нийтлэг хүрээг илэрхийлдэг”⁶ байна. Энэ бол дээрх судлаачид эртний Грек, Ромын улс төрийн уран үг бол нийтлэл зүй болон сэтгүүл зүйн эртний дүр мөн гэж хэлэх баталгаатай үндэслэл байгаагийн илэрэл юм. Энд өөр нэг зүйлийг тэмдэглэж хэлэх шаардлагатай. Тухайн үеийн уран илтгэгчид бол үл мэдэгдэх мэдээлэл дамжуулагчид байгаагүй, харин нэртэй нийгэм, улс төрийн зүтгэлтнүүд байсан бөгөөд тэд эртний хот, суурин газруудын бүхий л улс төрийн хэрэгт идэвхтэй оролцдог байжээ. Тухайлбал, Демосфений хамгийн алдартай, бусдыг байлдан дагуулсан улс төрийн үг нь Македони Афины тойргийг эзэлж авсан явдалтай холбоотой байсан бол Цицероны илтгэх урлаг нь МЭӨ 63 онд Каталины төрийн эсрэг гуйвалдааныг дарах, МЭӨ 44 онд Цезарийн дарангуйлал унасны

дараа бүгд найрамдах улс үндсээр нь салж бутрахын эсрэг чиглэгдсэн б-й гэж.

Хэрэв орчин үеийн тухай ярих юм бол уран илтгэгчид болон яруу илтгэгчдийн хоорондох эсрэг байр суурийн уламжлал өнөөдрийн мэдээлэл дамжуулагчид болон сэтгүүлчдийн дунд ч ажиглагддаг. Мэдээлэл дамжуулагчид бол зохиогч нь үл мэдэгдэх ямар нэгэн эх бичвэрийг зохиож, тэднийг ОНМХ-ийн янз бүрийн сувгуудыг ашиглаж түгээдэг хүмүүс юм. Мэдээлэл дамжуулагч бичгийн болон ярианы урлагийг гайхамшигтай эзэмшсэн, үндэслэлийг оновчтой гаргаж тавих, хүлээн авагчдад янз бүрийн аргаар нөлөөлөх чадвартай боловч эзэн-зохиогч нь ямагт олон түмнээс далд, үл мэдэгдэх онцлогтой юм. Реклам сурталчилгааны болон PR-ын мэргэжилтнүүд ч яг ийм байдгийг түвэггүй ажиглаж болно. Энэ мэргэжлийн өмнөх үеийн төлөөлөгчид бол хотын зам талбай болон захуудад янз бүрийн бараа таваарын үнэ ханш, сенатын зарлиг шийдвэрийг өндөр дуугаар уншиж танилцуулдаг эртний зарч тунхагчид гэж хэлж болно. Мөн сэтгүүлчийн мэргэжлийн өмнөх үеийн төлөөлөгчдийн тоонд хүлээн авагчдын өмнө өөрийнхөө улс төрийн үзэл бодол, үзэл суртлын байр суурь, хэлж буй үгийн зохиогч мөн гэдгийг ил тод чөлөөтэй хэлж чаддаг байсан эртний Грек, Ромын уран илтгэгчдийг нэрлэж болох бөгөөд гэхдээ тэдний ихэнх нь тухайлбал Цицерон амь насаараа хохирч байсан түүхтэй.

Улс төрийн уран илтгэгч болон нийтлэлчийн үйл ажиллагаа нь мэргэжлийн хувьд ойр байсан гэдгийг судлаач В. В. Учёнова аль аль нь улс төрийн хувьд цаг үеэ олсон практик үр нөлөөтэй, олон нийтийн санаа бодолд шуурхай хандсан

байдагт оршино гэж үзсэн байдаг⁷. Энэхүү уламжлал тодорхой хэмжээгээр хадгалагдаж байгааг бид өнөөдрийн сэтгүүл зүйгээс ажиглаж болно. Сэтгүүлчид өөрсдийн байр суурийг олны өмнө ил тод хамгаалж, эрх барьж буй засгийн газрыг чөлөөтэй шүүмжилж, улс төр, эдийн засгийн шинэчлэлийн талаар олон нийтийн хэлэлцүүлэг, маргаан, мэтгэлцээнд оролцох, амьдралын аль ч салбарын бодит байдлын талаар үнэн бодитой мэдээллийг өгч чаддаг. Эртний Грек, Ромын үеийнх шиг сэтгүүл зүй эздэд биш нийгмийн эрх ашгийн төлөө үйлчилдэг.

Үүнээс үзэхэд нийтлэл зүйн болон сэтгүүл зүйн онолын эх үндэс нь яруу үгийн уламжлалаасаа илүү илтгэх урлаг, түүх бичлэг, нийтлэлийн шинжтэй захиблаас гаралтай гэж хэлэх үндэстэй юм. Харилцааны онолын хөгжлийн үндэс болсон өөр зургаан уламжлал бол шинжлэх ухааны энэ салбар нь олон шинжлэх ухааны зааг дээр оршдогийг илтгэдэг онцлогтой юм. Анх XX зууны дунд үед Өрнөдөд үүсч, философи, социологи, сэтгэл судлал, улс төр судлал, хэл шинжлэл, соёл судлал, тэр ч байтугай техникийн шинжлэх ухааны зааг дээр хөгжиж ирсэн.

Үүнээс үзэхэд энэ шинжлэх ухааны цөм нь нийгэм-хүмүүнлэгийн болон техникийн шинжлэх ухааны шинжүүдийн нэгдлийн үндсэн дээр үүсч Баруун Европын орнуудад, дараа нь бусад оронд төлөвшсөн ажээ. Харилцааны онолын агуулгыг дараах зүйлүүд бүрдүүлдэг: 1) мэдээллийн ерөнхий онол, 2) утга зүйн онол, 3) хүмүүсийн хоорондох харилцан нөлөөллийн хөдөлгөөн, 4) нийгмийн харилцан нөлөөллийн социаль харилцаа ба институциональ хөдөлгөөн зэрэг юм⁸.

Зарим судлаач сэтгүүл зүйн онол бол нийгэм-хүмүүнлэгийн шинжлэх ухааны “хавсралт” судлагдахуун гэж үздэг нь үндэслэлгүй гэдэг нь тодорхой. Учир нь сэтгүүл зүйн гол шинжүүдийн нэг бол харилцааны үүрэг гүйцэтгэх явдал юм. Сэтгүүл зүйн онолыг судлах объект болон судлагдахуун нь түүний нийгмийн үзэгдэл болох бүх шинжүүдийн нийлбэр байдаг. Энэ тохиолдолд судлаачид зөвхөн түүний харилцааны тал биш, онтологийн, гносеологийн, деонтологийн, аксиологийн, соёлын болон антропологийн мөн чанарыг сонирхох учиртай. Эс тэгвэл сэтгүүл зүйн онолыг бүрэн гүйцэд ойлгох, таньж мэдэх боломжгүй юм.

Бидний бодлоор эрдэмтэд сэтгүүл зүйг мэдээлэл түгээх хэрэгсэлтэй адилтхан үзэхдээ томоохон алдаа гаргадаг нь ажиглагддаг. Шинжлэх ухаан техникийн хувьсгал сэтгүүл зүйн хөгжилд хүчтэй нөлөө үзүүлсэн нь үнэн. Гэхдээ түүнийг олон нийтийн харилцааны хэрэгсэлтэй ч, ОНМХ-тэй ч адилхан үзэх нь учир дутагдалтай. Сэтгүүл зүй аливаа оюуны боловсролын нэгэн адил материаллаг зөөгчгүйгээр оршин тогтнох боломжгүй. Гэхдээ сэтгүүл зүйн шинжлэх ухааны шийдвэрлэх асуудлуудын хүрээ нь мэдээллийг олшруулах, түгээх үйлдлээс хамаагүй өргөн, хамаагүй гүнзгий гэдэг нь ойлгомжтой. Үүнийг сэтгүүл зүйн нийгмийн үүрэг зорилгын асуудлууд, нийгмийн янз бүрийн системтэй харилцаа холбоонд оршдог, иргэний болон ардчилсан нийгмийг хөгжүүлэх болон бусад янз бүрийн нийгмийн үүргийг гүйцэтгэх зэрэг олон асуудалтай холбон тайлбарлаж болно.

Одоо энэ хоёр онолын онцлог, харилцан нөлөөллийн хүрээг нэлээд сайн төсөөлөхийн тулд тэдний объект,

судлагдахууныг харьцуулан үзэхийг оролдъё. Юуны өмнө шинжлэх ухаанд объект, судлагдахуун гэдгийг я х тодорхойлснийг авч үзье. Объект гэдэг нь субъектийн практик болон танин мэдэхүйн үйл ажиллагааны явцад түүний эсрэг тавьж буй зүйл мөн. Объект бол зөвхөн объектив бодит байдалтай адилхан зүйл төдийгүй түүний субьекттэй харилцан нөлөөлөлд оршиж буй тэр хэсэг мөн юм⁹.

Үүнээс үзэхэд объектив бодит байдлын тодорхой хил хязгаартай, харьцангуй бие даасан, түүнд судлаачийн танин мэдэхүйн сонирхол чиглэгдсэн тэр хэсэг л объектийн үүргийг гүйцэтгэдэг байна. Сэтгүүл зүй ба харилцаа бол судалгааны нарийн түвэгтэй объектод багтдаг. Тиймээс тэднийг судлах нь янз бүрийн шинжлэх ухааны зааг дээр зөвхөн шинжлэх ухааны ерөнхий аргуудаас гадна тусгай шинжлэх ухааны аргуудыг ашиглахыг шаарддаг¹⁰.

Орчин үеийн судлаачдын ихэнх нь харилцааны онолын объект болгон нийгмийн харилцааг эсвэл *Human communication*-ийг авч үздэг байна. Судлаач О. Л. Гнатюк нийгмийн харилцааны энэхүү харьцангуй өргөн ангилалд дараах дөрвөн шинжийг онцлон тэмдэглэсэн байдаг. Энэ бол 1) ухамсартай байх, 2) зорилготой байх, харилцаа нь зорилгын хувьд тодорхой байх, 3) түүний хэлбэр, 4) түүний түвшин юм¹¹.

Энэ нэр томъёо бол латины *communico* – холбож өгөх, хандах,

нийтийн болгох гэсэн утгыг илэрхийлдэг. Харин англи хэлэнд *communication* гэдэг нэр томъёо 1) хүний харилцаа хүмүүсийн хоорондох холбоо, 2) техник болон харилцааны хэрэгслүүдийн тусламжтайгаар хэрэгжиж буй холбоо, 3) мэдээллийг дамжуулах үйл явц¹² гэсэн гурван үндсэн утгыг илэрхийлдэг байна. Дээрх тодорхойлолтуудаас үзэхэд сэтгүүл зүйтэй холбоотой зүйл ажиглагдахгүй байна. Гол анхаарал хүний харилцааны явцад бий болдог хүмүүсийн хоорондын шууд, эсвэл дам харилцаанд төвлөрсөн байдаг.

«

Объект гэдэг нь субъектийн практик болон танин мэдэхүйн үйл ажиллагааны явцад түүний эсрэг тавьж буй зүйл мөн.

Объект бол зөвхөн объектив бодит байдалтай адилхан зүйл төдийгүй түүний субьекттэй харилцан нөлөөлөлд оршиж буй тэр хэсэг мөн юм

»

Үүнтэй холбогдуулан судлаач Д. П. Гавра "коммуникаци" гэдэг нэр томъёог уг утгаар нь авч үзвэл "хөдөлгөөн", "харилцан нөлөөлөл", "холбоо" зэрэг хамаагүй өргөн, нийтлэг ойлголтуудтай ижил бөгөөд нийгэм, байгаль дахь ямар нэг байдлаар хамтран, эсвэл нэг нь нөгөөгөөсөө хамааралтай орших үйл явцыг илэрхийлдэг¹³ гэж тэмдэглэжээ. Үүнээс үзэхэд суурь ойлголтын тоонд "хөдөлгөөн", "харилцан нөлөөлөл", "харилцаа холбоо"-г оруулсан бөгөөд тэдний тусламжтайгаар хэд хэдэн объектийн харилцан нөлөөллийн өвөрмөц төрөл болох нийгмийн харилцааны тусгай шинжүүдийг илэрхийлдэг¹⁴ байна. Гэхдээ харилцан нөлөөлөл ба хөдөлгөөний энэ төрөл нь дор хаяж хоёр субьект оролцсон нөхцөлд хэрэгжих боломжтой. Тийм субьектгүйгээр харилцаа хэрэгжих боломжгүй юм. Тиймээс "харилцааг амьд байгальд хамаарах объектууд оролцсон харил-

цан нөлөөлөл" гэж ойлгох нь түгээмэл юм¹⁵.

Харилцааны мөн чанарыг илэрхийлдэг шинж чанарын онцлогийг харгалзан түүнийг цаг хугацаа ба орон зай хэмээх нийтлэг үзэгдэлд хамруулан үзэх боломжтой юм. Энэ үзэгдэл үнэхээр харилцааны онолын объектийн судлах зүйл мөн гэдэг нь тодорхой боловч бүх юм үүсч, оршиж байгаа тэр хүрэнээс шууд шалтгаалах болно. Өөрөөр хэлбэл, мэлээлэл солилцох явцад оролцож буй янз бүрийн субьектүүдийн харилцан нөлөөллөөс шалтгаана гэсэн үг юм. Энэ харилцаа хүмүүсийн хоорондын эсвэл дам шинжтэй байж болно. Олон нийтийн харилцааны түвшинд объектийн үүргийг мэдээлэл түгээх сувгууд гүйцэтгэх бөгөөд тэдний тусламжтайгаар утга агуулгын хөдөлгөөн цаг хугацаа, орон зайн хүрээнд орших, хүмүүсийн хоорондох харилцаа холбоо, мэдээлэл солилцох боломж бүрдэнэ. Энд мэдээж харилцааны талаарх эрдэмтдийн санал дүгнэлтийг зуун хувь хүлээн зөвшөөрөх боломжгүй. Гэхдээ энд хамгийн гол асуудал сэтгүүл зүйн онолыг харилцааны онолтой харьцуулах явцад гарах нь тодорхой юм. Тухайлбал, зарим судлаач: "Харилцааны онолын объект бол сэтгүүл зүйн онолын объекттээс хамаагүй өргөн. Харилцааны онол олон нийтийн харилцааны янз бүрийн төрлүүд, тэдний онцлогоос гадна хүмүүсийн хоорондох харилцаа, бүлгийн хоорондох харилцаа зэрэг нийгмийн харилцааны түвшнүүдийг, мөн аман бус харилцааны төрлүүдийг судалдаг"¹⁶ гэж үздэг байна.

Энэ бол тийм ч оновчтой дүгнэлт биш юм. Учир нь харилцааны онолын объект нь харилцаа юм бол сэтгүүл зүйн онолын объект нь сэтгүүл зүй мөн

гэсэн маш энгийн логик гаргалгаа хийж болно. Энэ хоёр нийгмийн эрс өөр үзэгдэл гэдгийг хүлээн зөвшөөрсөн мөртлөө тэдний судлах объектийн зөвхөн нэг л талыг (харилцаа) барьж дүгнэлт хийдэг нь учир дутагдалтай юм. Сэтгүүл зүй бол зөвхөн харилцааны үйл явцад оролцох төдий зүйл биш, үйл ажиллагааны бие даасан хүрээ, нийгмийн институт, оюуны үйлдвэрлэлийн өвөрмөц салбар мөн. Түүний объектийн салбар нь сэтгүүл зүйн уг мөн чанараас шалтгаалан хоёрдмол шинжтэйгээс гадна олон бүрэлдэхүүн хэсэгтэй юм. Макротүвшинд түүнд ОНМХ-үүд ордог бол мезотүвшинд мэдээллийн байгууллагууд, микротүвшинд сэтгүүлчид багтдаг онцлогтой.

Сүүлийн үед эрдэмтэд сэтгүүл зүйн онолыг "бүтэц-үүргийн, институцийн, үүсэл-агуулгын, агуулга-үнэт зүйлсийн, үг зүйн шинжүүдийн нэгдэл"¹⁷ гэж үздэг болсон нь санамсаргүй зүйл биш юм. Энэ бол нэгдүгээрт, системийн үзэгдэлтэй холбоотой, хоёрдугаарт, сэтгүүл зүйн онолын объект нь зөвхөн харилцааны асуудлыг тусгайлан авч үзэх боломжгүй олон бүрэлдэхүүн хэсэгтэй, гуравдугаарт, судалгааны энэ объект нь мөн чанарын хувьд хоёрдмол шинжтэй гэдгийг гэдгийг илэрхийлж буй хэрэг мөн. Тиймээс нэг объектийн салбарыг нөгөөд нь хүчээр багтаах гэсэн аливаа оролдлого амжилт олж чадаагүй юм. Хэрэв тэгж үзэх хандлага давамгайлж, амжилт оллоо гэхэд нийгмийн энэхүү өвөрмөц үзэгдэл өөрийнхөө хамгийн гол шинжүүдийг алдах болно гэдэг нь тодорхой. Тиймээс утга зохиолыг ч, урлагийг ч, сэтгүүл зүйг ч харилцааны онолын объектод оруулах боломжгүй. Учир нь тэд мөн чанарын хувьд зөвхөн харилцааны үйл явцыг үүсгэгч

төдийгүй хүмүүсийн өөрийгөө хөгжүүлэх, илэрхийлэх, таньж мэдэх оюуны хэрэгцээ бөгөөд үүний үндсэн дээр харилцан нөлөөлөлд орших боломжтой юм.

Судлагдахуун бол хүний үйл ажиллагаа, танин мэдэхүйн үйл явцад тохиолддог объектуудийн дотроос онцгойлон авч үзэж буй тэдний нэгдмэл шинжийг илэрхийлдэг категори юм. Нэг объект судалгааны янз бүрийн төрлийн судлагдахуун байж болно. Объект ба судлагдахуун хоёрын гол ялгаа нь тухайн судалгааны онцлогоос шалтгаалан судлагдахуунд зөвхөн хамгийн гол, хамгийн чухал шинжүүд л ордог. Аль ч шинжлэх ухааны судлагдахууны онцлог шинж нь түүний үндсэн ойлголтуудын аппарат, судалгааны арга зүй, судалгааны тийм нарийн түвэгтэй объект бүхий бусад шинжлэх ухаантай харьцуулах болон практиктай холбогдох явцад илэрдэг онцлогтой. Үүнээс үзэхэд судлагдахууны дэлгэрэнгүй бүдүүвч нь түүний бүтэц (үндсэн ойлголтуудын аппарат, судалгааны арга зүй, объектийн хөгжлийн зүй тогтол), бусад шинжлэх ухаантай харилцаа холбоо, үүрэг зорилго, онолыг үргэлж баяжуулж байдаг практик холбоог агуулдаг байна¹⁸.

Харилцааны онолыг боловсруулагчдын ихэнх нь энэ бүдүүвчийн үндсэн дээр түүний судлагдахууныг тодорхойлсон байдаг. Бидний хувьд судалж буй хоёр чиглэлийн судлагдахууны ялгаагаас гадна тэдний нийтлэг хүрээг тодорхойлох нь энэхүү өвөрмөц нийгмийн үзэгдлүүдийг улам гүнзгий ойлгоход туслах болно.

Мэдээллийн ерөнхий онол бол бидний ярьж, бичиж буй зүйл яаж бүтдэг вэ, мэдээлэл яаж солилцох вэ, хүний харилцаанд оюуны ямар

асуудлууд хамаардаг вэ? зэрэг асуултад хариулт өгдөг. Үүнийг сэтгүүл зүйтэй холбон тайлбарлавал хэвлэл мэдээллийн нийтлэл, нэвтрүүлгийг бүтээх асуудлыг төдийгүй, түүний технологийг авч үздэг бичлэгийн төрөл зүйлийн ерөнхий онол гэсэн үг юм. Бидний бодлоор "мэдээллийн ерөнхий онол" гэсэн томъёолол нь мэдээллийн шинжтэй материалуудыг бүтээх гэсэн санааг агуулдаг гэж ойлгож болно. Гэхдээ сэтгүүл зүйд шууд мэдээлэл өгөх зорилго агуулаагүй шинжлэлт, нийтлэл-уран сайхны бичлэгийн төрөл зүйл байдгийг анхаарах хэрэгтэй. Тиймээс бичлэгийн төрөл зүйлийн онолыг бүхэлд нь мэдээллийн ерөнхий онолд багтаах боломжгүй юм. Харин мэдээлэл солилцох тухай асуудлыг бол мэдээллийг түгээх, олшруулах гэсэн утгаар ойлговол цэвэр техникийн шинжтэй бөгөөд энэ нь харилцааны онол гэхээсээ илүү мэдээлэл түгээгчидтэй холбоотой асуудал юм. Харин хүний харилцаанд оюуны ямар асуудлууд хамаардаг вэ? гэсэн асуултын хувьд өөр хэрэг. Гэхдээ тодруулах шаардлагатай зүйл бий. ОНМХ-үүдийн сувгуудад сэтгүүл зүйн бүтээлүүдээс гадна нийгмийн оюуны янз бүрийн асуудлуудыг хөндсөн уран сайхны, уран зохиолын, урлагийн бүтээлүүдийг түгээдэг нь энгийн үзэгдэл. Үүнээс үзэхэд мэдээллийн ерөнхий онол нь сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйлийн системтэй зөвхөн зарим шинж чанарын хувьд ойролцоо байгаа нь тодорхой юм.

Харилцаа бол нийгмийн үзэгдэл болохын хувьд янз бүрийн нийгмийн институтуудын хоорондох харилцааг хангах хэрэгслийн үүргийг гүйцэтгэдэг. Энэ тохиолдолд сэтгүүл зүйг зүгээр нэг хэрэгсэл биш бие даасан нийгмийн институт гэсэн утгаар авч үздэг.

Тиймээс сэтгүүл зүй яриа, эх бичвэр, дуу чимээ, дүрс зэрэг харилцааны арга хэлбэрүүдийг ашигладаг. Мөн сэтгүүл зүй "дөрөв дэх засаглал"-ын хувьд хяналтын үүргийг гүйцэтгэж, нийгмийн янз бүрийн хэсэг бүлгүүдийн хоорондох харилцаа болон олон нийтийн санаа бодолд нөлөөлөх боломжтой юм. Тиймээс энэ тохиолдолд түүний судлагдахууны хүрээ нь харилцаа биш, харин институциональ шинжтэй болох нь тодорхой юм.

Харилцаа бол өөрөө дангаараа юу ч бүтээхгүй, юу ч үйлдвэрлэхгүй. Харилцаа бол зөвхөн мэдээлэл дамжуулах хэрэгсэл, хувь хүмүүс болон нийгмийн институтуудын үйлдвэрлэсэн тодорхой агуулга бүхий хэсгүүдийн хөдөлгөөний хэлбэр юм.

Энэ хоёр шинжлэх ухааны салбарын объект болон судлагдахуунд дүн шинжилгээ хийсний үр дүнд тэд агуулгын хувьд өөр өөр зүйл гэсэн дүгнэлт хийж болно. Судалж буй хоёр онол арга зүйн өөр өөр бааз дээр төлөвшсөн учраас тэдний статус, нийгэмд эзлэх байрыг тодорхойлох хандлага ч өөр байна. Сэтгүүл зүйг харилцааны онолын салбар ухаан гэж үзэх нь үндэслэлгүй юм. Учир нь сэтгүүл зүйн үзэгдлийг зөвхөн түүний харилцааны шинжийг харгалзан тайлбарлах ямар ч боломжгүй. Сэтгүүл зүйн уг мөн чанар нь нийтлэл, нэвтрүүлгийг бэлтгэх бүтээлч үйл ажиллагаатай холбоотой учраас юуны өмнө энэ асуудалд гол анхаарлаа төвлөрүүлэх шаардлагатай юм.

Ишлэл

- ¹ Сидоров В. А. 2005. Динамика мира журналистики. Как в теории связать нити? // Журналистика в мире политики / Ред. В. А. Сидоров. СПб., с. 132.

- ² Прохоров Е. П. 2002. Структура и проблемы деонтологии // Вестник МГУ: "Журналистика". №4, с. 13.

- ³ Гнатюк О. Л. 2007. К вопросу о деонтологических основаниях политической журналистики // Теория журналистики: в поисках смысла, структуры и назначения. Ред. М. Н. Ким. СПб., с. 58-59.

- ⁴ Гнатюк О. Л. 2008. Основы теории коммуникации. СПб., с. 6.

- ⁵ Там же, с. 27.

- ⁶ Учёнова В. В. 1989. У истоков публицистики. М., с. 8.

- ⁷ Там же, с. 8.

- ⁸ Гавра Д. П. 2005. Основы теории коммуникации. СПб., с. 12-13.

- ⁹ 1972. Философский энциклопедический словарь / Под ред. М. М. Розенталя. М., с. 308-309.

- ¹⁰ Там же, с. 8.

- ¹¹ Электронный англо-русский словарь. АBBYY Software House (BIT Software)

- ¹² Гавра Д. П. Указ. соч., с. 23.

- ¹³ Там же, с. 24.

- ¹⁴ Там же, с. 25.

- ¹⁵ Гнатюк О. Л. 2008. Теория журналистики и теория коммуникации: компаративный анализ "предметных полей" исследования // Теория журналистики: анализ концепций / Ред. М. Н. Ким. СПб., с. 36.

- ¹⁶ Коркунесонко С. Г. 2010. Теория журналистики. М., с. 42.

- ¹⁷ Гнатюк О. Л. Указ. соч., с. 8-9.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Блохин И. Н. 2007. Антропология журналистики: интерпретации, основания, действующие лица // Теория журналистики: в поисках смысла, структуры и назначения. Ред. М. Н. Ким. СПб.
2. Гавра Д. П. 2005. Основы теории коммуникации. СПб.
3. Гнатюк О. Л. 2008. Основы теории коммуникации. СПб.
4. Гнатюк О. Л. 2007. К вопросу о деонтологических основаниях политической журналистики // Теория журналистики: в поисках смысла, структуры и назначения. Ред. М. Н. Ким. СПб.
5. Гнатюк О. Л. 2008. Теория журналистики и теория коммуникации: компаративный анализ "предметных полей" исследования // Теория журналистики: анализ концепций / Ред. М. Н. Ким. СПб.

6. Зулькафиль М. 2007. Орчин үеийн Монголын сэтгүүл зүй. УБ.

7. Зулькафиль М. 2011. Монголын олон нийтийн мэдээлэл: нэг үзэл суртал ба олон ургальч үзэл хүртэл. УБ.

8. Зулькафиль М. 2012, 2014. Сэтгүүл зүйн онолын зарим асуудал. Цуврал №4-5. УБ.

9. Корконесонко С. Г. 2010. Теория журналистики. М.

10. Прохоров Е. П. 2002. Структура и проблемы деонтологии // Вестник МГУ: "Журналистика". №4.

11. Сидоров В. А. 2005. Динамика мира журналистики. Как в теории связать нити? // Журналистика в мире политики / Ред. В. А. Сидоров. СПб.

12. Учёнова В. В. 1989. У истоков публицистики. М.

13. 1972. Философский энциклопедический словарь / Под ред. М. М. Розенталя. М.

14. Электронный англо-русский словарь. ABBYY Software House (BIT Software)

Резюме

В статье рассматриваются теоретико-методологические вопросы создания общей теории журналистики и проблемы, связанные с трудностью в разработке этой теории. Автор подчёркивает о необходимости самоопределения теории журналистики среди других социально-гуманитарных наук и разработки категориальной системы теории журналистики. Также автор анализируя предметные области теории журналистики и теории коммуникации, сделал вывод о том, что они разные по содержанию, формировались на разных методологических базах, поэтому имеют разные подходы в определении их статуса.